

  
 БАТЛАВ  
 ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА  
 Б.АСРАЛТ

**АВЛИГЫН ЭСРЭГ ҮНДЭСНИЙ ЧУУЛГАНААС ГАРГАСАН  
ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Төрийн албаны шударга, ил тод байдлыг бэхжүүлэх чиглэлээр

| д/д | Зөвлөмж  | Хэрэгжүүлэх арга хэмжээ  | Гүйцэтгэлийн үзүүлэлт   | Хэрэгжүүлэх субъект               | Хэрэгжүүлэх болон тайлагнах хугацаа |
|-----|--|--|---|-----------------------------------|-------------------------------------|
| 1   | Төрийн байгууллагын шударга байдлын үнэлгээ, авлигын эрсдлийн үнэлгээ зэрэг судалгааны үр дүнд тулгуурлан авлигын эрсдэл бүхий салбар, байгууллагад чиглэсэн арга хэмжээг тусгайлан авч хэрэгжүүлэх, авлигын гэмт хэрэг, авлига, ашиг сонирхлын зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах | 2.1.АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, телезохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр иргэд, олон нийтэд хүргэх | ГЕГ болон харьяа гаалийн газар хороодод АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, телезохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, гарын авлага зэргийг албан ёсны цахим хуудас customs.gov.mn, Mongolian customs пэйж хуудас, “Монголын гааль” твиттер болон ГЕГ-ын мэдээллийн сурталчилгааны самбарт байршуулж, иргэд олон нийтэд хүргэсэн байна. | ГЕГ-ын ХНХ, Гаалийн газар, хороод | Жилдээ<br>2022.06.02;<br>2022.12.02 |

|   |   |   |   |                                       |                                     |
|---|---|---|---|---------------------------------------|-------------------------------------|
| 2 | Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо системдийг хөгжүүлэх, ашиглалтыг нэмэгдүүлэх, уг өгөгдөлд суурилж төрийн албан хаагчийн томилгоог хийх.       | Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо цахим системийн гаалийн байгууллагын албан хаагчдын мэдээллийг шинэчлэн бүрдүүлэх, баяжуулалт хийх  | Уг цахим системд албан хаагчдын мэдээллийг үнэн зөв оруулж, албан хаагчийн үндсэн болон бусад мэдээлэлд өөрчлөлт орох тухай бүр өөрчлөлтийг оруулж, баяжуулсан байна. Мэдээлэлд суурилж томилгоог хийсэн байна.   | ГЕГ-ын ХНХ                            | Жилдээ<br>2022.06.02;<br>2022.12.02 |
| 3 | Төрийн албаны хууль тогтоомжоор албан тушаалд тавьсан шаардлагыг хангаагүй, сонгон шалгаруулалтгүйгээр томилсон хүмүүсийг төрийн албанаас чөлөөлөх ажлыг зохион байгуулах | Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилтыг хангах | Гаалийн байгууллагын сул орон тоог нөхөх Төрийн жинхэнэ албан хаагчийн тусгай шалгалтыг зохион байгуулах захиалгыг Төрийн албаны зөвлөлийн Сангийн яамны дэргэдэх салбар зөвлөлд хүргүүлсний үндсэн дээр шалгалтын комисс байгуулагдсан байна.<br><br>Төрийн албаны зөвлөлийн албан ёсны цахим хуудаст нээлттэй сонгон шалгаруулалтын зарыг нийтэлж, албан тушаалын тодорхойлолтод тэнцсэн иргэдийг бүртгэсэн байна. Ингэснээр сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилгод бүрэн нийцсэн байна. | ГЕГ-ын ТЗУГ, ХНХ                      | Жилдээ<br>2022.06.02;<br>2022.12.02 |
| 4 | Төрийн албан дахь статистик, тоон мэдээллийн үнэн зөв байдлыг хангах, гүйцэтгэлийн үр дүн, мэдээллийн үнэн зөв байдлыг хангаж ажиллах                                     | Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад мэдээллийг сар бүр гаалийн байгууллагын албан ёсны цахим хуудаснаа байршуулах  | Гаалийн байгууллагын улсын төсвийн орлогын болон гадаад худалдааны статистик, төсөв санхүү, худалдан авах үйл ажиллагааны мэдээллийг customs.gov.mn, tender.gov.mn, shilendans.gov.mn, Mongolian customs пэйж хуудас, "Монголын гааль" твиттер болон ГЕГ-ын   | Статистикийн хэлтэс, ТОГ, СХОХ, ХМССТ | Жилдээ<br>2022.06.02;<br>2022.12.02 |

|   |  |   |   |   |                                     |
|---|--|---|---|---|-------------------------------------|
|   |  |   | мэдээллийн самбарт байршуулж олон нийтийг мэдээллийн ил тод байдлаар хангаж ажилласан байна.  |   |                                     |
| 5 | Төрийн худалдан авалт, ханган нийлүүлэлт, хөгжлийн албан ёсны тусламж, татаас, тэтгэмж, хөтөлбөр болон эрх, тусгай зөвшөөрөл, концесс олгох зэрэг үйл ажиллагаатай холбоотойгоор авлигын гэмт хэрэг гарахад нөлөөлөхүйц хүчин зүйлсийг арилгах | Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх. | Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг, заасан хугацаанд нь гаалийн байгууллагын албан ёсны цахим хуудаснаа тавьж хэвшүүлсэн байна.  | СХОХ  | Жилдээ<br>2022.06.02;<br>2022.12.02 |
| 6 | Цахим засаглалыг хөгжүүлэх, "e-mongolia" цахим системээр үзүүлэх төрийн үйлчилгээний төрөл, тоо чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх   | Төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх   | Гаалийн байгууллагаар үйлчлүүлж байгаа аж ахуйн нэгж, иргэдэд үзүүлж буй үйлчилгээг цахим хэлбэрээр авах боломжийг судалж, Гаалийн цахим үйлчилгээний системд (www.gaali.mn) нэвтрүүлсэн байна. | МТТ, ГХШГ, ГЭУХ, ГЗТХБГ, ГБГ, ТОГ, БДШГ, ГТЛ, ХМССТ | Жилдээ<br>2022.06.02;<br>2022.12.02 |